



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А1514

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, 28 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3.12 дугаар зорилтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад мөрдөх түр журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай.

2.1. Журмын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газар /Б.Гантулга/, цахим сургалтын бэлтгэл ажлыг ханган, үр дүнтэй зохион байгуулахыг Боловсролын мэдээллийн технологийн төв /Ц.Нямхүү/, багшийн хөгжлийг дэмжин, холбогдох зөвлөмж, чиглэл өгч ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/-т;

2.2. Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хичээлд шилжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн /М.Итгэл/-д, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж ажиллахыг Боловсролын үнэлгээний төв /М.Ганбат/-д;

2.3. Цахим сургалт зохион байгуулахаар шалгарсан багш нарын ажиллах нөхцөл, сонголт нь баталгаажсан суралцагчдын суралцах боломжийг хангах, эцэг эх асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэн ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад;

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар /П.Оюунаа/-т даалгасугай.


САЙД



П.ЭНХ-АМГАЛАН

142211910

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн  
А.5.14 дүгээр тушаалын хавсралт



## **АХЛАХ АНГИЙН СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХАД МӨРДӨХ ТҮР ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг зүйл**

- 1.1. Ахлах ангийн сургалтын төлөвлөгөөний сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Боловсролын мэдээллийн технологийн төв /цаашид "төв" гэх/ нь ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөж буй сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн жилийн бүтэц, суралцагчийн үнэлгээний журам, цахим журнал хөтлөх журам болон бусад холбогдох дүрэм журмыг баримтлан ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулна.
- 1.3. Суралцагчийн хэрэгцээ, сонирхол, мэргэжил сонголт, мэргэжлийн багшийн хангалт, бүлэг дүүргэлтэд үндэслэн, сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр судлах сонголт нь баталгаажсан суралцагчид цахим сургалтад хамрагдана.
- 1.4. Төв нь энэ журмын 1.1-д заасан сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах үйл ажиллагааг Боловсролын ерөнхий газартай хамтран удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.
- 1.5. Төв нь судлагдахуун бүрийн ахлах багш, цахим сургалтын менежер, хичээл заах багшийг сонгон шалгаруулж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллана.
- 1.6. Сонгон шалгаруулалтад тэнцсэн багш, судлагдахууны ахлах багш, цахим сургалтын менежерийг нийтэд нь "цахим сургалтын баг" гэнэ.

### **Хоёр: Сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад баримтлах зарчим**

- 2.1. Сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад доор дурдсан зарчмыг баримтална.
  - 2.1.1. Суралцагчдын сонголтод үндэслэсэн байх;
  - 2.1.2. Мэдээллийн технологид суурилсан байх;
  - 2.1.3. Боловсрол эзэмших тэгш боломжоор хангасан байх;
  - 2.1.4. Ил тод, шударга, эргэх холбоотой байх;
  - 2.1.5. Хамтын ажиллагаанд суурилсан байх;
  - 2.1.6. Багш, сурагчийн нэр хүндийг хүндэтгэсэн байх;

## **Гурав. Цахим сургалтын удирдлага, зохион байгуулалт**

3.1. Журмын 1.2-т заасан байгууллага нь ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах удирдамжийг боловсруулан баталж аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсээр дамжуулан сургууль бүрт хүргүүлнэ.

3.2. Журмын 1.4-т заасан байгууллагууд ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэс, ерөнхий боловсролын сургуулийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

3.3. Сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад Боловсролын мэдээллийн технологийн төв нь доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3.1. цахим сургалтын “medle.mn” суралцахуйн удирдлагын системийн найдвартай байдлыг хангаж, программ хөгжүүлэлт хийх;

3.3.2. цахим сургалт зохион байгуулахтай холбоотой бүртгэл, судалгааг тогтоосон хугацаанд хийн, мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах;

3.3.3. цахим сургалт зохион байгуулах багш нарыг бүртгэн, сургалт зохион байгуулж, шалгарсан багш нартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах;

3.3.4. сонгон судлах хөтөлбөрийг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээр хянуулж, батлуулах;

3.3.5. цахим сургалт зохион байгуулах арга зүйн зөвлөмж, жишиг төлөвлөлтийг системд байршуулан цахим сургалтын орчин бүрдүүлж ажиллах;

3.3.6. төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын ахлах ангийн суралцагчдаас хичээл сонголтын судалгааг 9 дүгээр сарын 15-ны дотор системээр дамжуулан авч сонголтыг баталгаажуулах;

3.3.7. цахим сургалтын хуваарь, хичээл зааж буй багшийн мэдээлэл, суралцагчдын хичээл сонголт, цахим сургалтын зохион байгуулалтын талаар аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсээр дамжуулан ерөнхий боловсролын сургуулийг шаардлагатай мэдээллээр хангах;

3.3.8. цахим сургалтын үеийн хичээлийг хадгалах, мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн тогтвортой байдлыг ханган эргэх холбоотой ажиллах;

3.3.9. оролцогч талуудад мэдээлэл дамжуулах, мэдээлэл хүлээн авах, ашиглах, хамтран эзэмших үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах;

3.4. Сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад Боловсролын ерөнхий газар нь доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4.1. нийслэл, орон нутгийн боловсролын байгууллагын ахлах мэргэжилтнүүд болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын менежерүүдэд цахим сургалтын хэрэгжилтийг хангах сургалт зохион байгуулах;

3.4.2 цахим хичээл заах, цахим сургалтад хамрагдах багшийн судалгаа гаргаж, хүний нөөцийг бүрдүүлэн, багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр төвтэй хамтран ажиллах;

3.4.3. цахим сургалтын ирц, оролцоо, суралцагчийн үнэлгээ, багшийн баримт бичиг хөтлөлтийн талаар аймаг, нийслэлийн боловсролын газар хэлтэс, ерөнхий боловсролын сургуулийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

## **Дөрөв. Цахим сургалт зохион байгуулах**

4.1. Ерөнхий боловсролын сургууль нь 9 дүгээр сарын 15-ны дотор ахлах ангийн суралцагчдад системд хичээл сонголт хийх аргачлалыг таниулж, анги удирдсан багш, эцэг эх, асран хамгаалагчдыг цахим сургалттай холбоотой мэдээллээр хангана.

4.2. Цахим сургалтыг Улаанбаатарын цагаар 15:00-17:00 цагт зохион байгуулна.

4.3. Цахим сургалт нь асинхрон, синхрон холболтоор зохион байгуулагдах бөгөөд асинхрон холболт нь "medle.mn" суралцахуйн удирдлагын системээр, синхрон холболт нь Microsoft Teams программаар зохион байгуулагдана.

4.4. Цахим сургалтад хамрагдах суралцагч, багш нар нь албан ёсны Microsoft Office 365 хаягаар сургалтын үйл ажиллагаанд оролцоно.

4.5. Сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад цахим сургалтын менежер нь доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.5.1. "medle.mn" суралцахуйн удирдлагын системд баталгаажсан суралцагчдын хичээл сонголтод үндэслэн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хуваарийг боловсруулан, төвийн захирлаар батлуулж, аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсээр дамжуулан ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэх;

4.5.2. цахим сургалтын багийг арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавин, шаардлагатай мэдээллийг Боловсролын ерөнхий газарт хүргүүлж, шуурхай удирдлагаар хангаж ажиллах;

4.5.3. суралцагчийн ирц, оролцоо, явцын болон хагас жилийн үнэлгээ, эцсийн үнэлгээний дүн, цахим журнал хөтлөлтөд хяналт тавьж, үнэлгээний мэдээллийг аймаг нийслэлийн боловсролын газар, хэлтсээр дамжуулан ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэх;

4.6. Хичээл заах багш нь ахлах ангийн сонгон судлах хичээлийг зааж байсан туршлагатай, агуулгын болон сурах үйлийн дэс дараалал, уялдаа холбоог хангах арга зүй эзэмшсэн, бие даан суралцах, үнэлэх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах арга зүйд суралцсан, хөгжих хүсэл эрмэлзэлтэй, хариуцлагатай байх бөгөөд доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.6.1. цахим сургалтын явцад гүйцэтгэх лаборатори, дадлага ажил, семинар, туршилт, төсөлт ажлыг сонгон судлах хөтөлбөрт нийцүүлэн боловсруулж багш, сурагчийн ашиглах хэрэглэгдэхүүн, контентийн сан, үнэлгээний даалгаврын сан бүрдүүлсэн байх;

4.6.2. цахим сургалтын үед ашиглах контентийг сургалтын нээлттэй материал, сургалтын интерактив контент, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн цахим контентод тавигдах шаардлагын дагуу боловсруулсан байх;

4.6.3. цахим хичээлийн хэрэглэгдэхүүн, ашиглах программын заавар, бие даан судлах материал, эх сурвалж, линкийг бэлтгэн системд байршуулж, үр дүнг тооцож ажиллах;

4.6.4. нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулан, цахим журналыг зааврын дагуу хөтөлж, анги удирдсан багшийн үүргийг биелүүлж ажиллах;

4.6.5. нэгж, бүлэг сэдвээр үнэлгээний даалгавар боловсруулан, суралцагчийг хагас, бүтэн жилээр үнэлэн, цахим журнал, хувийн хэрэгт тэмдэглэх, дүн үнэлгээг баталгаажуулах;

4.7. Цахим сургалтын баг нь цахим хичээлийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин, үр дүнд шинжилгээ хийж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын менежертэй эргэх холбоотой, хамтран ажиллана.

### **Тав. Талуудын үүрэг, оролцоо**

5.1. Сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад боловсролын байгууллагууд дараах үүрэг, оролцоотой ажиллана.

5.1.1. Боловсролын үнэлгээний төв нь цахим сургалт зохион байгуулах багш нарт сонгон судлах хичээлийн үнэлгээний даалгавар боловсруулах, гүйцэтгэлийг үнэлэх арга зүйн сургалтыг зохион байгуулах;

5.1.2. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь цахим сургалтын багт ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хичээлд шилжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

5.1.3. Аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэс нь ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчдын хичээл сонголтын судалгааг тогтоосон хугацаанд хийлгэж, сонголтоо баталгаажуулах, бусад шаардлагатай мэдээллээр сургуулиудыг хангаж ажиллах;

5.1.4. Ерөнхий боловсролын сургууль нь дараах үүрэг, оролцоог хангаж ажиллана.

5.1.4.1. сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр суралцах боломжийг суралцагчдад нээлттэй олгон, суралцахуйн удирдлагын системд нэвтрэх, хичээл сонголтыг хийх, баталгаажуулах, хамрагдах арга зүйн сургалтыг суралцагчдад зохион байгуулах;

5.1.4.2. сонгон судлах хичээлд цахимаар суралцах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэн, гурвалсан гэрээнд тусган, биелэлтэд хяналт тавьж ажиллах;

5.1.4.3. цахим хичээл заахаар шалгарсан багшид сургалтын өрөө, интернэтийн орчин, лаборатори, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэн, хичээлээс бусад нэмэлт ажлаар ачаалахгүй байхад анхаарах;

5.1.5. Цахим сургалт зохион байгуулах багш нь цахим ур чадвараа хөгжүүлэх, хэрэглэгдэхүүн, контентийн сан бүрдүүлэх, үнэлгээний даалгавар боловсруулах чиглэлээр гэрээнд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн, багшийн хөгжлийн төлөвлөгөөтэй ажиллах;

5.1.6. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги даасан багш нь сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр судалж буй суралцагчдын ирц, оролцоонд хяналт тавин эцэг эх, асран хамгаалагчдыг тогтмол мэдээллээр хангах;

5.1.7. Сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр суралцах эрх нь баталгаажсан суралцагч нь хичээлийн хуваарийн дагуу сургалтад тогтмол хамрагдаж, хичээл судлах зааварчилгаатай танилцан, бие даан суралцах үйлийг төлөвлөн, өөрийн удирдлагатай суралцах;

5.1.8. Хүндэтгэн үзэх шалтгаанаар цахим сургалтад хамрагдаагүй суралцагчид цахим хичээлийн багшид мэдэгдэн, системд хадгалагдсан хичээлийг нөхөн үзэж, бие даалтыг хийн, ирцийг тооцуулах;

## **Зургаа. Хориглох зүйл**

6.1. Суралцагч нь цахим сургалтын хичээл, агуулга, видео, аудио хичээлүүд болон бусад файл, бие даалт болон гэрийн даалгаврыг бусдад дамжуулахыг хориглоно.

6.2. Багшийн зүгээс албан ёсны зөвшөөрөлгүй ном, гарын авлага, цахим болон бичмэл материал, бусад зүйлийг зохион байгуулалттайгаар эцэг эх, асран хамгаалагчид, суралцагчдаас худалдан авахыг шаардахыг хориглоно.

6.3. Багш нь боловсролын нээлттэй нөөц материалаас бусад материалыг хуулбарлан ашиглахыг хориглоно.

## **Долоо. Хяналт, үнэлгээ, тайлан**

7.1. Цахим сургалтын баг нь ажил гүйцэтгэсэн гэрээний хэрэгжилтийг төвд тайлагнана.

7.2. Боловсролын ерөнхий газар нь багшийн цахим ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

7.3. Боловсролын үнэлгээний төв нь хичээлийн жилийн эцэст хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийж журмын 1.4-т заасан байгууллагуудад тайлан, мэдээллийг хүргүүлнэ.

7.4. Төв нь журмын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ хийж, хагас, бүтэн жилээр үндэсний хэмжээнд тайлагнана.

7.5. Төв нь цахим сургалт зохион байгуулсан тухай тайлан мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч, нэгтгэн, боловсруулж Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

## **Найм. Бусад**

8.1. Цахим сургалтыг зохион байгуулахтай холбоотой энэхүү журамд тусгагдаагүй асуудлыг ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад журмаар зохицуулна.

8.2. Цахим сургалт зохион байгуулах багш нарыг урамшуулах, дэмжих үйл ажиллагааг тухайн багштай байгуулж буй гэрээнд тодорхой тусгана.

8.3. Оюуны өмчийн зөрчилтэй холбоотой маргааныг оюуны өмчийн эрх, түүнд холбогдох хууль, журмаар шийдвэрлэнэ.

8.4. Цахим сургалттай холбогдон гарсан санал, гомдлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.